



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ийн 2024 оны
санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨВА-2025/006/НА-СТА-ОНӨҮГ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323833 Цахим хаяг: khorloosuren@audit.gov.mn

Аудитор: Р.Мягмарсүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: myagmarsuren@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.14 № 141
танай _____-ны № _____-т

ОНГИ УС СУВАГ ТБОНӨО
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ХОРОЛСҮРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Онги ус суваг ТБОНӨО ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Онги ус суваг ТБОНӨО ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант онд ТУЗ-ийн тогтоолоор баталсан зорилтот түвшний төлөвлөгөөг 335.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "Нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3,578.8 сая төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч бүртгэсний 3,576.4 сая төгрөгийн орлого нь үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, 2.3 сая төгрөгийн орлого нь үнэ төлбөргүй авсан бараа материалын орлого байна. Аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн а/77 тоот захирамжаар 27.6 сая төгрөгийн өртөгтэй Арвайхээр сумын 5-р багийн 1,5,13,14 дүгээр байрны шугам засвар, 275.0 сая төгрөгийн өртөгтэй гэр

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

6225020132

хорооллын усан санг цахимжуулах, тоног төхөөрөмж нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгөөр 225.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тус тус бүртгэж авсан байна. Тайлант онд цалингийн зардалд 1,672.6 сая төгрөг, түлш шатахууны зардалд 128.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>629,129,172.06</u>	<u>511,315,056.26</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	112,603,209.73	18,051,473.05
311	Кассад байгаа бэлэн мөнгө	3,455,182.07	1,507,295.90
31110	Төгрөг	3,455,182.07	1,507,295.90
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	109,148,027.66	16,544,177.15
3121	Төгрөг	109,148,027.66	16,544,177.15
31213	Арилжааны банк дахь харилцах	109,148,027.66	16,544,177.15
33	АВЛАГА	114,402,403.47	99,228,214.82
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		2,606,400.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	113,451,482.10	96,621,814.82
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	950,921.37	
35	БАРАА МАТЕРИАЛ	402,123,558.86	394,035,368.39
354	Хангамжийн материал	402,123,558.86	394,035,368.39
35420	Аж ахуйн материал	402,123,558.86	394,035,368.39
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,301,709,200.01</u>	<u>9,407,033,813.54</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,301,709,200.01	9,407,033,813.54
392	Биет хөрөнгө	9,249,115,949.98	9,357,765,563.47
393	Биет бус хөрөнгө	52,593,250.03	49,268,250.07
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,930,838,372.07</u>	<u>9,918,348,869.80</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>54,344,873.80</u>	<u>110,293,499.76</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	54,344,873.80	110,293,499.76
413	Өглөг	54,344,873.80	110,293,499.76
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	719,974.30	1,473,373.00
4136	Бусад өглөг	53,624,899.50	108,820,126.76
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	45,868,838.13	70,609,254.89
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	7,756,061.37	38,210,871.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>9,876,493,498.27</u>	<u>9,808,055,370.04</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	9,876,493,498.27	9,808,055,370.04

Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,607,576,940.00	1,984,503,420.00
51101	Өмч: - төрийн	1,607,576,940.00	1,607,576,940.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	-	376,926,480.00
512	Хуримтлагдсан үр дүн	7,994,425,531.29	7,549,060,923.06
51210	Өмнөх үеийн үр дүн	7,994,425,531.29	7,994,425,531.29
51220	Тайлант үеийн үр дүн		(445,364,608.23)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	274,491,026.98	274,491,026.98
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,930,838,372.07</u>	<u>9,918,348,869.80</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого (Цэвэр)	2,450,320,401.76	3,576,447,268.70
2	Борлуулалтын өртөг	2,359,871,334.21	3,526,529,690.67
3	Нийт ашиг (алдагдал)	90,449,067.55	49,917,578.03
8	Бусад орлого	3,156,799,647.78	2,316,929.89
8.1	Орлогын дүн	3,156,799,647.78	2,316,929.89
9	Борлуулалт, маркетингийн зардал	172,400,142.29	240,667,119.02
10	Ерөнхий ба удирдлагын зардал	224,961,952.11	256,534,497.13
12.1	Зардлын дүн	397,362,094.40	497,201,616.15
17	Бусад ашиг (алдагдал)	98,714.12	-397,500.00
17.1	Олз, гарзын дүн	98,714.12	-397,500.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,849,985,335.05	-445,364,608.23
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,849,985,335.05	-445,364,608.23
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,849,985,335.05	-445,364,608.23

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзний өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,607,576,940.00	274,491,026.98		5,144,440,196.24	7,026,508,163.22
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө,					

Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				2,849,985,335.05	2,849,985,335.05
9	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,607,576,940.00	274,491,026.98		7,994,425,531.29	9,876,493,498.27
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				-445,364,608.23	-445,364,608.23
14	Өмчид гаргасан өөрчлөлт			376,926,480		
17	2024 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,607,576,940.00	274,491,026.98		7,994,425,531.29	9,876,493,498.27

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,678,912,334.69	3,963,458,847.38
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэн орлого	2,330,403,447.98	3,574,395,618.52
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	279,919,302.00	270,900,000.0
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	68,589,584.71	118,163,228.86
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,653,613,235.02	3,872,194,811.36
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,125,858,307.91	1,664,687,895.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	153,599,771.19	212,026,480.35
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	361,583,505.00	534,559,822.67
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	332,595,148.27	385,867,898.01
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	330,142,682.01	502,907,207.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	93,720,951.20	227,580,590.80

**Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	2,723,267.20	
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	253,394,602.24	344,565,017.41
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,299,099.67	91,264,036.02
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	73,517,200.00	185,815,772.70
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	73,517,200.00	185,815,772.70
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-73,517,200.00	-185,815,772.70
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-48,218,100.33	-94,551,736.68
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	160,821,310.06	112,603,209.73
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	112,603,209.73	18,051,473.05

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны гүйцэтгэл	2023 оны Тодотгол		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	2,757,233,428.59	3,688,359,447.10	4,024,128,806.82	-335,769,359.72	
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	2,757,233,428.59	3,688,359,447.10	4,024,128,806.82	-335,769,359.72	109.10
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,715,193,432.60	3,619,723,899.10	3,953,348,382.82	-333,624,483.72	109.22
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,166,939,588.78	1,687,382,541.44	1,672,595,924.10	14,786,617.34	99.12
1 Үндсэн ба нэмэгдэл цалин	1,122,268,778.05	1,616,902,541.44	1,602,115,924.10	14,786,617.34	99.09
2 Унаа хоолны хөнгөлөлт	44,670,810.73	70,480,000.00	70,480,000.00	0.00	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	151,684,214.07	214,875,431.79	211,584,055.16	3,291,376.63	98.47
1 Тэтгэврийн даатгал	95,504,875.53	135,291,938.53	133,219,590.29	2,072,348.24	98.47
2 Тэтгэмжийн даатгал	8,988,694.17	12,733,358.92	12,538,314.38	195,044.54	98.47
3 ҮОМШӨ-ний даатгал	22,471,735.42	31,833,397.30	31,345,785.95	487,611.35	98.47
4 Ажилгүйдлийн даатгал	2,247,173.54	3,183,339.73	3,134,578.59	48,761.14	98.47
5 Эрүүл мэндийн даатгал	22,471,735.42	31,833,397.30	31,345,785.95	487,611.35	98.47
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	295,987,292.13	342,545,099.59	344,848,696.77	(3,392,177.18)	100.67
1 Гэрэл, цахилгаан	278,644,782.84	317,677,039.59	320,731,809.50	-3,054,769.91	100.96
2 Түлш, халаалт	17,342,509.29	20,591,960.00	20,929,367.27	-337,407.27	101.64
3 Цэвэр бохир ус		4,276,100.00	3,187,520.00	1,088,580.00	74.54
Хангамж, бараа материалын зардал	551,265,246.51	514,963,119.09	710,036,965.71	(195,073,846.62)	137.88
1 Бичиг хэрэг	10,353,697.74	11,792,095.82	22,563,154.12	-10,771,058.30	191.34

**Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2	Тээвэр, шатахуун	179,896,669.44	122,117,535.27	118,878,563.06	3,238,972.21	97.35
3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,694,698.60	18,968,200.00	17,605,034.10	1,363,165.90	92.81
4	Ном хэвлэл	214,800.00	716,000.00	124,100.00	591,900.00	17.33
	Түлш шатахуун, тээврийн хөлс	165,299,402.01	140,360,571.00	161,043,875.94	-20,683,304.94	114.74
	Усны лабораторийн зардал		10,045,520.00	19,243,561.59	-9,198,041.59	191.56
	Авто сэлбэг		89,156,700.00	242,722,176.90	-153,565,476.90	272.24
7	Аж ахуйн материал худалдан авахад	182,805,978.72	121,806,497.00	127,856,500.00	-6,050,003.00	104.97
	Нормативт зардал	16,298,531.82	61,202,000.00	73,219,836.53	(12,017,836.53)	119.64
1	Эм бэлдмэл эмийн хэрэгсэл				0.00	
	Хоол хүнс	16,298,531.82	27,652,000.00	33,848,817.27	-6,196,817.27	122.41
	Нормын хувцас, зөөлөн эдлэл		33,550,000.00	39,371,019.26	-5,821,019.26	117.35
	Эд хогшил, урсгал засварын зардал	104,942,956.80	136,101,046.00	264,851,354.45	(128,750,308.45)	194.60
1	Багаж, техник, хэрэгсэл	8,546,921.81			0.00	
5	Хөдөлмөр хамгааллын зардал	47,441,716.64	32,991,046.00	61,515,982.24	-28,524,936.24	186.46
6	Урсгал засвар	48,954,318.35	103,110,000.00	203,335,372.21	-100,225,372.21	197.20
	Томилолт, зочны зардал	4,289,900.00	21,381,200.00	21,139,000.00	242,200.00	98.87
1	Дотоод албан томилолт	4,289,900.00	21,381,200.00	21,139,000.00	242,200.00	98.87
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,079,412.96	166,347,053.48	189,481,729.81	(4,118,336.80)	113.91
1	Харуул, хамгаалалтын зардал	54,241,417.21	44,996,800.00	44,679,454.54	317,345.46	99.29
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар		4,679,350.00	4,674,047.73	5,302.27	99.89
	Ариутгалын зардал		5,907,600.00	7,377,272.54	-1,469,672.54	124.88
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		5,050,283.48	31,001,627.57	-25,951,344.09	613.86
	Төлбөр хураамж		15,049,692.00	10,255,597.95	4,794,094.05	68.14
3	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,680,000.00	2,310,000.00	2,310,000.00	0.00	100.00
	Зохицуулалтын үйлчилгээний хөлс		14500000	14475876	24,124.00	99.83
4	Үйлдвэр үйлчилгээний зориулалтаар ашигласан усны татвар		12,334,658.00	12,334,598.95	59.05	100.00

**Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

5	Тээврийн хэрэгслийн татвар	2,463,104.90	1,518,445.00	1,517,510.00	935.00	99.94
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	72,000.00	608175	608175	0.00	100.00
6	Газрын төлбөр	15,592,046.00	15,592,050.00	15,592,052.00	-2.00	100.00
7	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,200.62			0.00	
	ТУЗ-ын зардал		10,800,000.00	7,213,600.00	3,586,400.00	66.79
	Бусад зардал	15,018,644.23	33,000,000.00	37,441,917.53	-4,441,917.53	113.46
Бараа үйлчилгээний бусад зардал		334,706,289.53	474,926,407.71	465,590,820.29	9,335,587.42	98.03
1	Бараа үйлчилгээний бусад зардал	9,056,900.00	5,270,000.00	4,615,000.00	655,000.00	87.57
2	Сургалт семинар	4,491,288.00	3,385,000.00	3,558,181.12	-173,181.12	105.12
3	Элэгдлийн зардал	321,158,101.53	466,271,407.71	457,417,639.17	8,853,768.54	98.10
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		42,039,995.99	68,635,548.00	70,780,424.00	(2,144,876.00)	103.13
1	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	32,583,068.72	51,695,548.00	55,983,424.00	-4,287,876.00	108.29
2	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	9,456,927.27	16,940,000.00	14,797,000.00	2,143,000.00	87.35
НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН ДҮН		2,450,419,115.88	3,620,158,543.60	3,603,391,471.32	16,767,072.28	99.54
НИЙТ ОРЛОГЫН ДҮН		2,450,419,115.88	3,620,158,543.60	3,603,391,471.32	16,767,072.28	99.54
1	Борлуулалтын орлого	2,170,401,099.76	3,349,158,543.60	3,212,011,312.57	137,147,231.03	95.91
2	Санхүүгийн дэмжлэг	279,919,302.00	271,000,000.00	270,900,000.00	100,000.00	99.96
3	Бусад орлого	98714.12		120,480,158.75	-120,480,158.75	
НИЙТ САНХҮҮЖИЛТИЙН ДҮН			112,603,209.73			0.00
4	Оны эхний үлдэгдлээс		112,603,209.73			

5. Аудитын илрүүлэлт

Бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их буюу алдаа, зөрчилтэй байсан тул *хязгаарлалттай* дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 464.4 сая төгрөгийн зөрчил илэрч 464.4 сая төгрөгийн 2 албан шаардлага өгч, тайлант онд ТУЗ-ийн тогтоолоор баталсан зорилтот түвшний төлөвлөгөөг 335.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь материаллаг зөрчил гэж үзлээ.

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1 :

1. Тайлант онд ТУЗ-ийн тогтоолоор баталсан зорилтот түвшний төлөвлөгөөг 335.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн

16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"; 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

2. Тайлант онд 128.6 сая төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4-т "хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-д "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно", 10.3-д "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", 31 дүгээр зүйлийн 31.1 -д "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" гэсэн заалтууд, Монгол улсын засгийн газрын 2024 оны "Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай" тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

5.3 Зөвлөмж

Илрүүлэлт 1 :

Тайлант оны санхүүгийн төлөвлөлтөд тодотгол хийхдээ дараа оны 1 сард ТУЗ-ийн тогтоол гарсан нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д "Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно" гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 4 дүгээр сарын 15-ны дотор, зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хэрэгжүүлж, нотлох баримтын хамт 2025 оны 6 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Алдаа гараагүй													
Дүн	0	0	0	0	0	0	0	0	00	00	0	0	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс
--------------------	-------------	--------

Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ТБОНӨО ХХК-ний 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны санхүүгийн төлөвлөлтөд тодотгол хийхдээ дараа оны 1 сард ТУЗ-ийн тогтоол гарсан байна.	1	-					1	-				
Тайлант онд ТУЗ-ийн тогтоолоор баталсан зорилтот түвшний төлөвлөгөөг 335.8 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	1	335,769.4			1	335,769.4						
Дүн	2	335,769.4			1	335,769.4	1	-				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Дүн	0	0	0	0	00	0
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуультай холбоотой зөрчил						
Тайлант онд 128.6 сая төгрөгийн шатахууны худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	128,608.7	1	128,608.7		
Нийт дүн	1	128,608.7	1	128,608.7	000	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

